

452



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/689

Номгон

Аймгийн аварга малчин өрх, хошой аварга малчин өрх, аварга саальчин шалгаруулах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрх шалгаруулах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Аймгийн аварга саальчин шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын дагуу тодорхойлолтыг хүлээн авч жил бүрийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Баттөр/-т үүрэг болгосугай.

3.Шагналд шаардагдах хөрөнгийг жил бүрийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсугай.

4.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/794 дүгээр захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН  
С.Тогтоо Бат

Аймгийн Засаг дарга  
2021.11.11  
601210600

Аймгийн Засаг даргын... дүгээр  
сарын...-ний өдрийн... дүгээр  
захирамжийн... дүгээр хавсралт



## АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХ, АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг боловсронгуй болгох, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын сүүлийн 3-5 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрхөөр жил бүр шалгаруулна.

1.3. Аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрхөд шагнал олгох шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуйн газраас оруулсан саналыг үндэслэн Засаг дарга шийдвэрлэнэ.

### Хоёр. Шагналд тодорхойлогдох малчин өрхөд тавигдах шаардлага

2.1. Аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрхөөр шагнуулахаар тодорхойлогдох малчин өрх нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1. Аймгийн хошой аварга малчин өрхөд тодорхойлогдох малчин нь аймгийн аварга малчин болсноос хойш 5-аас доошгүй жил, аймгийн аварга малчин өрхөд тодорхойлогдох малчин нь сумын аварга малчин өрх болсноос хойш 3-аас доошгүй жил амжилттай ажилласан байх,

2.1.2. Бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай, малын зүй бус хорогдол гаргаагүй байх,

2.1.3. Сүрэгт эзлэх хээлтэгчийн тоо сүүлийн 3 жил дараалан тогтвортой өссөн, сүрэгт эзлэх хувийн жин нь бог малд 50-аас, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хурч сүргийн бүтцийг зохистой түвшинд хангасан, нийт малын 30-аас доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх,

2.

2.1.4. Оны эхний 100 хээлтэгч тутмаас бойжсон төлийн тоо нь тухайн жилийн аймгийн дунджаас илүү байж, хээлтэгч бүрээс төл бойжуулсан, өнжөөж төллүүлсэн бол хөдөө аж ахуйн тасгаас тайлбар ирүүлсэн байх.

2.1.5. Мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол, бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй байх.

2.1.6. Тухайн бүс нутагт үржүүлдэгийг зөвшөөрсөн төрөл, ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх, мал сүргээ үзлэг ангилалтад технологийн хугацаанд нь хамруулахаар жил бүр мал үржүүлэг, технологийн нэгж буюу хөдөө аж ахуйн тасагтай гэрээ байгуулж ажилласан байх.

2.1.7. Үржлийн малыг дахин давтагдахгүй хувийн дугаараар ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, үржлийн малын удам гарваль, ашиг шим, үр төлийн чанарын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн удам гарвалийн гэрчилгээтэй, мэдээлэл нь үндэсний бүртгэл мэдээллийн санд орсон байна.

2.1.8. Бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг технологийн нэгжид ялган төвлөрүүлж, чанар стандартын шаардлага хангасан, удам зүйн үнэлгээнд хамрагдсан хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтын дор ашигладаг байх.

2.1.9. Хонин толгойд шилжүүлснээр нэг малд хангай, тал хээрийн бүсэд 20 кг, говийн бүсэд 10 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, тэжээлийг жил бүр бэлтгэн нөөцөлдөг байх.

2.1.10. Жил бүр малын сүргийн эргэлтийн төлөвлөлт хийж, сүргийн зохистой бүтэц болон бүтээгдэхүүний орлого зарлагаа төлөвлөн, малаа эдийн засгийн эргэлтэд оруулж, сум орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулан түр болон байнгын ажлын байрыг бий болгон ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх.

2.1.11. Баталгаажих түвшингээс доош орлоготой 2-оос доошгүй өрхийн хүүхдийн эмчилгээ, боловсрол эзэмшихэд дэмжлэг тусламж үзүүлэн, нийгэмд тодорхой хувь нэмэр оруулж хандив тусламж өгсөн байх.

2.1.12. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаатай, өвөлжөө, хаваржааныхаа бэлчээрийг гэрээгээр ашигладаг, бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг ээлгэн өнжөөх, отор нүүдэл хийх, зэргээр зохистой ашигладаг, бэлчээр хамгаалах

талаар сум, багаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд идэвхитэй оролцдог, бэлчээр ашиглах маргаан зөрчилгүй байх,

2.1.13. Мал сүргээ жилийн 4 улиралд өөрөө малладаг, уламжлалт болон сүүлийн үеийн мал маллагааны арга туршлагын талаар ахмад малчдаас суралцах, залуу малчдад эзэмшүүлэх санаачилга гарган ажиллаж 2-оос доошгүй шавь малчинтай болсон байх,

2.1.14. Малчин өрхийн хүн бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаж шимтгэл төлсөн, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх, хүн амын орлогын албан татварыг хугацаанд нь төлсөн байх,

2.1.15. МAA-н үйлдвэрлэлээс тухайн жилд олсон нийт орлогын 10-аас доошгүй хувиар хашаа хороо барих, засварлах, тохижуулах, доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг шандны эхийг хамгаалах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн, банкинд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх,

2.1.16. Малын тоо, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний дүнд бусдаас худалдаж авсан болон бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг тооцохгүй.

**Гурав. Аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой малчин өрх шалгаруулах**

3.1. Багийн Засаг дарга сумын хөдөө аж ахуйн тасагтай хамтран энэ журмын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа малчны бичиг баримтыг тухайн багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж зөвхөн 1 тодорхойлолтыг аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.2. Сумын Засаг даргын Тамгын газар нь энэ журмын шалгуур үзүүлэлтийг хангасан, сүүлийн 5-аас доошгүй жил амжилтаа ахиулан ажилласан аймгийн аварга малчин өрхийг аймгийн хошой аварга малчин өрхөд, сүүлийн 3-аас доошгүй жил амжилтаа ахиулан ажилласан сумын аварга малчин өрхийг аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар 3 хүртэл тодорхойлолтыг багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлнэ. Журамд зааснаас илүү тодорхойлолт ирүүлсэн сумын тодорхойлолтыг шалгаруулахгүйгээр буцаана.

3.3. Сумдаас ирүүлсэн тодорхойлолт бусад баталгаажсан бичиг баримтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар хянан үзэж, газар дээр нь шалган дүгнэлт гарган, шаардлага шалгуур үзүүлэлт хангаснаар нь эрэмбэлэн аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар бичиг баримтыг нь шалган баталгаажуулж, тухайн жилийн сар шинийн баяраас өмнө Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

#### Дөрөв. Тодорхойлолт бүрдүүлэх

Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхийг тодорхойлохдоо дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

- 4.1.1. Малчны /эхнэр, нөхрийн/ товч анкет /хүснэгт 1-ийн дагуу/ ✓
- 4.1.2. Ажлын үзүүлэлт /хүснэгт 2-ын дагуу/ ✓
- 4.1.3. Иргэний үнэмлэхний хуулбар ✓✓
- 4.1.4. Малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр ✓✓
- 4.1.5. Сумын аварга малчин өрхийн үнэмлэхний хуулбар ✓
- 4.1.6. Аймгийн аварга малчин өрхийн үнэмлэхний хуулбар /хошой аваргад хамаарна/
- 4.1.7. Ажил байдлын тодорхойлолт ✓
- 4.1.8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлсөн тухай цахим лавлагаа ✓
- 4.1.9. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт ✓
- 4.1.10. Үржлийн малд үзлэг ангилалт хийлгэх талаар байгуулсан гэрээ, ✓ тодорхойлолт —
- 4.1.11. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ, малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар, тодорхойлолт ✓
- 4.1.12. Ялган тэмдэглэгээ хийлгэж үндэсний бүртгэл мэдээллийн санд оруулсан малын жагсаалт
- 4.1.13. Хөрөнгө оруулалт хийж, бүтээгдэхүүн нийлүүлсэн болон тусламж ✓ авсан байгууллага, иргэний тодорхойлолт, баталгаа, бүртгэж авсан орлогын болон адилтгах баримт ✓
- 4.1.14. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, өвөлжөө, хаваржааны ✓ бэлчээр ашиглах гэрээ, бэлчээр ашиглалтын зураглал ✓
- 4.1.15. Эзэмшлийн өвөлжөө, хаваржааны гэрчилгээний хуулга ✓
- 4.1.16. Баталгаажуулсан фото зураг ✓✓

5.

4.1.17.Багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, тэмдэглэл ✓

4.1.18.Сумын Засаг даргын хүсэлт \_\_\_\_\_

4.1.19.Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай банкны тодорхойлолт ✓

4.1.20.Сумын Засаг даргын тамгын газраас газар дээр нь шалгасан дүгнэлт  
Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөд тодорхойлогдож байгаа малчны ажлын үзүүлэлт, тодорхойлолтын үнэн зөвийг баг, сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, Хөдөө аж ахуйн тасгийн холбогдох мэргэжилтэн, тодорхойлолтын бүрэн гүйцэд байдлыг ЗДТГазар хариуцна.

**Тав.Шагнал олгох**

5.1.Аймгийн хошой аварга малчин өрх, аварга малчин өрхөөр шалгарсан малчдыг гэр бүлийн хамт энгэрийн тэмдэг, өргөмжлөл болон бусад шагналаар шагнана. Шагналын нийт дүн 1000,0 /нэг сая/ төгрөг байна. Энгэрийн тэмдэг, өргөмжлөл, бусад шагналын худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

5.2.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнээс өмнө хүндэтгэлтэйгээр гардуулна.

5.3.Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрх шагналаар шагнагдсан малчны өвөлжөө, хаваржааг "Аймгийн аварга малчин ....., "Аймгийн хошой аварга малчин....." /овог нэр бичнэ/ гэж хаягжуулж алдаршуулах асуудлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

5.4. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхийн шагнал гардуулах ажлыг тухайн сумын Засаг даргын тамгын газар, сумаас сонгогдсон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Засаг даргын зөвлөлийн гишүүд, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, холбогдох мэргэжилтнүүд аймаг, сумын төвд нэгдсэн байдлаар зохион байгуулж аварга малчин өрхийг алдаршуулна.

Аймгийн аварга малчнаар шалгаруулах  
журмын 2 дугаар хавсралт

АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХӨД ТОДОРХОЙЛЖ БАЙГАА  
..... СУМЫН МАЛЧИН..... -НЫ  
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он..... сар..... өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		он 3	он 4	он 6
1	2			
Нэг.Малын төрөл тоо				
1.Оны эхний мал /бодод шилжүүлснээр/	Бүгд			
2.Оны эхний мал	Бүгд			
Үүнээс	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	ямаа			
3. Хээлтэгч	Бүгд			
Үүнээс	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Хонь			
4.Хээлтүүлэгч	Бүгд			
	Буур			
Үүнээс	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
5.Бойжуулсан төл	Бүгд			
Үүнээс	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
6.Зах зээлд борлуулсан мал	Бүгд			
Үүнээс	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Бүгд			
7.Үржилд худалдсан мал	Бүгд			
Үүнээс	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			

2.

1	2	3	4	5
8.Малжуулахад өгсөн мал  Үүнээс	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
9.Оны эцэст тоологдсон мал  Үүнээс	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
10.Оны эцэст байгаа хээлтэгч  Үүнээс	Бүгд			
	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Хонь			
	Ямаа			
11.Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	Бүгд			
	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
<b>Хоёр.Малын ашиг шим ашиглалтын байдал</b>				
2.1.Оны эхнээс нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг/  Үүнээс	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
2.2.Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн ноос, ноолуур /кг/	Тэмээний ноос, кг			
	Хонины ноос, кг			
	Ямааны ноолуур, кг			
	Нийлбэр			
2.3.үйлдвэрлэсэн сүү, сүүн бүдээгдэхүүн	Цагаан идээ /кг/			
	Сүү /литр/			
	Нийлбэр			
2.4.Амьд мал борлуулсанаас олсон орлого /мян.төг/	Адуу			
	Тэмээ			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Нийлбэр			
2.5.Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мян.төг/	Мал борлуулснаас			
	Мах борлуулснаас			
	Ноос борлуулснаас			



3.

1	2	3	4	5
	Ноолуур борлуулснаас			
	Цагаан идээ борлуулснаас			
	Сүү борлуулснаас			
	Арьс борлуулснаас			
	Шир борлуулснаас			
	Нийлбэр			
Гурав. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн материаллаг бааз				
3.1. Өрхийн хэмжээнд бэлтгэсэн өвс, хүчит тэжээл, хужир /тн/	Өвс			
	Гар тэжээл			
	Хүчит тэжээл			
	Хужир			
3.2. Хадлангийн талбай	Талбайн хэмжээ м2			
	Авсан ургац тн			
3.3. Хашаа, худаг	Хашааны тоо			
	Багтаамж толгой мал			
	Худгийн тоо			
	Хүчин чадал /л/сек/			
3.4. Хөрөнгө оруулалт /мян. төг/	Худаг			
	Малын хашаа, хороо			
	Бэлчээр сайжруулах			
	Хадлангийн талбай хамгаалах			
Дөрөв. Татвар болон эрүүл мэнд, нийгмийн даатгал төлөлт				
4.1. Татвар төлөлт /ХХОАТ/	Төгрөгөөр			
4.2. Малын индексжүүлсэн даатгал	Даатгуулсан малын тоо			
	Төлсөн хураамж			
4.3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			
4.4. Нийгмийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			

Тайлбар: Дээрхи үзүүлэлтүүдийг улсын тооллого бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН  
 ..... СУМЫН ..... БАГИЙН ЗАСАГ ДАРГА  
 ..... / ..... /  
 ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН  
 ..... / ..... /